## САЛБАР ХУРАЛДААН- 5

## ХАВДРЫН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ

**Модератор: С.Төгсдэлгэр, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга**

---

**Хэлэлцүүлсэн илтгэл:**

1. **Хувь хүний хөгжлийн сургалт**
2. **Хорт хавдрын тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах нь**
3. **Хорт хавдрын, эрт илрүүлгийн тогтолцоог бэхжүүлэх нь**

### НЭГ. ЭРХЗҮЙН ОРЧИН, ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Хавдрын тусламж үйлчилгээг задлах, аймаг дүүргийн эмнэлгүүд лавлагаа шатлалын тусламжийг үзүүлдэг болох
2. Хорт хавдрын тусламж үйлчилгээг үзүүлэх эрхзүйн орчинг сайжруулах
3. Тусламж үйлчилгээний стандартыг шинэчлэх, хавдрын тусламж үйлчилгээг жагсаалтанд оруулах
4. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх чиглэлээр эхлүүлсэн төсөл хөтөлбөрийн тасралтгүй байдлын санхүүгийн болон эрхзүйн орчин нөхцлийг хангах
5. Аймаг бүрт эрт илрүүлгийн төвийг байгуулах, ажиллах орчинг бүрдүүлэх, мотив үүсгэх
6. Анхан шатны байгууллагад мөрдөгдөх эрт илрүүлгийн тушаалуудыг эргэж харах, мөрдүүлэх, шахах
7. Нэг чиглэлийн үйл ажиллагааг давхардуулсан хөтөлбөр, эрт илрүүлэгийг нэгтгэх
8. Хүний нөөцийг хангалт, сургалт, төрөлжүүлэхэд бодлогоор туслах
9. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг салгаж тусдаа статустай болгох, бие даан ажиллах эрхзүйн орчинг бүрдүүлэх
10. Аймаг бүрийн зонхилох тохиолдох хавдраас сэргийлэх урьдчилан сэргийлэх алгоритмыг гаргаж эрт илрүүлгийг нарийсгаж ажиллах
11. “Монгол улсын Засгийн газрын үйл ажиллага аны хөтөлбөр 2020-2024” – хэрэгжүүлэх хүрээнд баталсан ЭМС-ын 2021 оны А/360 дугаар тушаал “ХАВДРЫН ЭСРЭГ” арга хэмжээний төлөвлөгөөний:

- Хэрэгжилтийг манлайлах,
- Салбар хоорондын уялдааг удирдан зохион байгуулах

Дараах үйл ажиллагааг 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж бий болгох. Үүнд:

1. “Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө”-ний санхүүжилтийг шийдвэрлэх,
2. Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт үнэлгээ хийх үүрэг бүхий орон тооны бус “Удирдах хороо” байгуулах (Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах

хөтөлбөрүүдийн эсвэл нийгмийн эрүүл мэндийн бодлого хөтөлбөрийн гэсэн нэгдсэн байж болох )

3. “Тамхины хяналтын тухай хууль”-ийн нэмэлт өөрчлөлт оруулах
4. Хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр боловсруулах батлах
5. Хавдрын эрт илрүүлэг үзлэгийн товлол шинэчлэх, холбогдох журам, зааврыг шинэчлэх
6. ХПВ-ийн дархлаажуулалтын хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, дархлаажуулалтын товлолд оруулж, нэвтрүүлэх
7. Эрт илрүүлгийн тогтолцоо бүрдүүлэх: ХСҮТ-ийг түшиглэн байгуулах эрт илрүүлгийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг батлах, Аймаг, дүүргийн хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн нэгжийг байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх
8. Хавдрын тусламж үйлчилгээ (химиэмчилгээ, хөнгөвчлөх тусламж, мэс засал, туяа эмчилгээ)-ний чанар, хүртээмжийг аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд нэмэгдүүлэх, сайжруулах хүрээнд ЭМС-ын 2015 оны А/351 тушаалыг шинэчлэн аймаг, нийслэлийн хавдрын тусламж үйлчилгээний журам (хавдрын тасаг, кабинетийн хүний нөөц, орны тоо, үзүүлэх тусламж үйлчилгээний жагсаалт г.м)-ыг шинэчлэн батлах,
9. Аймаг дүүрэгт хавдрын тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх, засвар үйлчилгээ хийх санхүүжилтийг шийдвэрлэх

**ХОЁР. ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Удирдамж, зааврудыг шинэчлэх
2. Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийн ашиглалт, хүртээмжийг нэмэгдүүлэх
3. Эмч нарын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эмч бүр эдийн шинжилгээ авах , түүнд оношилгоо хийх чадвартай байх
4. Шинжилгээний хариу, эргэн мэдээлэл ирэх хугацааг богиносгох
5. Химийн эмчилгээний тасралтгүй байдал, чанартай байдлыг хангах
6. Хавдрын эмчилгээ, оношлогоо, эрт илрүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эрт илрүүлэгийн дараах хяналт, эмчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүлэх
7. Анхан шатны тусламж үйлчилгээний оношлогооны чадварыг нэмэгдүүлэх
8. Орон нутагт хавдрын тасаг, хавдрын орны тоог нэмэгдүүлэх
9. Өрх сумын эмч, сувилагч нарыг чадавхижуулж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх (хөнгөвчлөх)
10. Шатлал бүрт үзүүлэх хавдрын тусламж үйлчилгээг стандарт, удирдамжийн дагуу, нарийн мэргэшсэн эмч мэргэжилтэн нар үзүүлэх
11. Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/351 тушаалын дагуу хавдрын тасаг байгуулах, түүнд ажиллах орон тоог нь батлах (Аймаг дүүрэг

хавдрын тусламж үйлчилгээнд зориулан 15 –с цөөнгүй ор ажиллуулах)

12. ЭМС-ын 2021 оны А/360 дугаар тушаалын дагуу эрт илрүүлгийн нэгжийг байгуулах хүний нөөц, тоног төхөөрөмжийг хангах асуудлаар аймаг, дүүргийн Засаг дарга, ИТХ гэх мэт холбогдох байгууллагатай хамтран ажиллах
13. Хими эмээр тасралтгүй хангаж, химийн эмчилгээг орон нутагт хийх

a. Дэмжих тусламж, үйлчилгээ (сэтгэл зүй, нийгмийн ажилтан, хоол зүй)-ний хүртээмжийг нэмэгдүүлэх

2. Эмгэг судлалын шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэх
3. Дүрс оношилгоо, дурангийн оношилгооны чадавх (хүний нөөц, тоног төхөөрөмж)-ийг нэмэгдүүлэх
4. Дүрс оношилгоонд PACS систем нэвтрүүлэх
5. Хавдрын мэс заслыг бүсчлэн хөгжүүлэх Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөл, нас баралтыг 2025 он хүртэл 20 хувиар бууруулах, зорилго тавих ажиллах
6. Хавдрын эрт оношилгооны орчин шинэ арга технологиудыг нэвтрүүлэх
7. Хавдрын оношилгоо, эмчилгээний удирдамж, зааврудыг шинэчлэн
8. боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх, холбогдох эмч, мэргэжилтэнүүдийг сургах, чадавхижуулах
9. Хавдрын молекул биологийн оношилгооны чадавхийг нэмэгдүүлэх
10. хими эмчилгээний эм бэлдмэлийн тоо хэмжээг нэмэгдүүлэх
11. Эмгэг судлалын лабораторийн чадавхийг сайжруулах
12. Мэс засал эмчилгээнд нөхөн сэргээх мэс заслын шинэ арга технологиийг нэвтрүүлэх
13. Нейронкологи, онкоурологийн нэгж байгуулах, хөхний төвийн чадавхийг нэмэгдүүлэх
14. Баруун бүсийн туяа эмчилгээний төв байгуулах
15. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний журам шинэчлэх, хүний нөөцийг чадавхижуулах ажлыг зохион байгуулах
16. Хавдрын сэргээн засах тусламж үйлчилгээг бэхжүүлэх, сувилал байгуулах
17. Хавдрын бүртгэл, тандалтын программ хангамжийг сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх
18. Хавдрын сувилахуй, Хөнгөвчлөх сувилахуйн мэргэжилтнийг бэлтгэх, чадавхижуулах

## ГУРАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

1. Орон нутгийн эмч, сувилагч, бүртгэгч нарын тоог нэмэгдүүлэх
2. Ажиллах хүчний тасралтгүй сургалтыг хангах, ур чадварыг нэмэгдүүлэх Хавдрын мэргэшсэн хүний нөөцийг багаар нь сургах, хангах, бэлтгэх
3. Эмч солилцоо, урамшууллын тогтолцоо, тэтгэлэгт хөтөлбөр
4. Хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах
5. Орон нутгийн эрүүл мэндийн сэтгэл зүйчийг мэргэшүүлэх
6. Эрт илрүүлэгийн тусдаа эмч  мэргэжилтэнтэй болох

7. Орон нутагт хавдрын эмчийн ажлын орон тоог нэмэгдүүлэх
8. Эрүүл мэндийн сайдын 2015 оны А/351 тушаалын дагуу хавдрын тасаг байгуулах, түүнд ажиллах орон тоог  нь батлах (Аймаг дүүрэг хавдрын тусламж үйлчилгээнд зориулан 15 –с цөөнгүй ор ажиллуулах)

**ДӨРӨВ. ТАНДАЛТ, СУДАЛГАА, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Мэдээ, мэдээлэл, сургалтын хэлбэрийг олшруулах, сургалтын үр өгөөжийн нэмэгдүүлэх
2. Эрт илрүүлэгийг эрт эхлүүлэх
3. Программ хангамж, эрт илрүүлэг, эргэн дуудах, бүртгэлийн тогтолцоог хөгжүүлэх
4. Жил бүр эрдэм шинжилгээний хурал, уулзалт зохион байгуулах
5. ХПВ-ийн дархлаажуулалтын эрх зүйн орчин бүрдүүлэх, үндэсний товлолд оруулах ажилд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх

**ТАВ. САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Шинжилгээ, эмчилгээний өртөгийн ЭМД-д өөр өөрөөр үнэлсэн байна, үнэлгээг ижил  болгох, нэмэгдүүлэх
2. Тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх
3. Хавдрын тусламж үйлчилгээ, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн өртөгийн жинг нэмэгдүүлэх
4. Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан бол үзүүлэх хөнгөлөлт байх
5. Өрх, сумын ЭМД-аас авах санхүүжилтэнд эрт илрүүлгийн санхүүжилтийг тусгах
6. Аймгийн нэгдсэн эмнэлэгт өдрийн химийн өртөг, хавдрын өндөр өртөгтэй хагалгааны үеийн санхүүжилтыг нэмэгдүүлэх
7. Хими эмчилгээний бокс-ыг орон нутгийн бүх эмнэлэгт хангах

**ЗУРГАА: ХАМТЫН АЖИЛЛАГАА, ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:**

1. Орон нутгийн удирдлагын дэмжлэг, хамтын ажиллагаа
2. Хувийн болон улсын эрүүл мэндийн байгууллагын түншлэл, хамтын ажиллагааг хангах
3. Бусад байгууллагуудтай хамтын ажиллагаагаар хангаж оролцоог нэмэгдүүлэх
4. Төрийн болон төрийн бус байгууллага, салбар хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, ажилчдын эрт илрүүлэг үзлэгийн хувийг нэмэгдүүлж хавдрын эрт илрүүлгийг оруулах

5. Орон нутгийн удирдлагууд, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн нөөц боломжийг ашиглаж тушаал, заавар журмын хэрэгжилтийг хангах (хавдрын ор, хавдрын эмчилгээг эхлүүлэх, өргөжүүлэх)
6. Эрт илрүүлгийн чиглэлээр ажилладаг бүх салбар нэгжүүдийн (хувийн хэвшил болон улсын эмнэлэг) уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн тогтолцоог нэгтгэх.

## 7 Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр

1. Иргэдийн эрүүл мэндийг боловсролыг дээшлүүлэхэд сургалт сурталчилгааны шинэ арга стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх, цахим, технологийн дэвшилд суурилсан зөвлөмж боловсруулах
2. Эрт илрүүлгийн тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр

ЭМС-ын 2021 оны А/360 дугаар тушаалаар “ХАВДРЫН ЭСРЭГ” арга хэмжээний төлөвлөгөөний 3-р зорилтын хэрэгжилтийг хангаж ажиллахад удирдлага, зохион байгуулалтаар хангах, Эрт илрүүлгийн үндэсний сүлжээ ажиллах дүрэм журмыг боловсруулан ЭМЯ-аар батлуулах , Эрт илрүүлгийн үндэсний сүлжээ бүрдүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмжийн болон хүний нөөцийн судалгаа тооцоо хийх Хүний нөөцийг бэлтгэх, чадавхижуулах ажлыг аймаг, дүүргүүдтэй хамтран хийх